



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/04

Арвайхээр

Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 035/01 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссоос 2019 оны 11 дүгээр сард аймгийн өвөлжилтийн нөхцөлд хийсэн үнэлгээгээр 16 суманд эрсдэлийн түвшин их, 2 сум дунд 1 сум бага эрсдэлтэй гарсан байх тул зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 10000 (арван мянга) боодол өвсийг 89000000 (наян есөн сая) төгрөгөөр Далайгүүр ХХК-иас худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, өвс тэжээлийг чанар, баглаа боодол, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, хуваарилалт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100007